

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Аймгийн Онцгой комиссын хүрээнд: Улсын Онцгой комиссын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдаанаар баталсан Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын ажиллах журам, Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай хууль тогтоомжууд, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан даалгавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссоос 2021 оны 03 дугаар сард дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комисс 2021 оны тайлант 3 дугаар сард 4 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 10 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 2 тогтоол, аймгийн Засаг даргын 1 захирамж, Онцгой комиссын даргын 1 тушаал, АОК-ын дэргэдэх шуурхай штабын 1 шийдвэр, 1 тогтоол үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллав.

Улсын Онцгой комиссын даргын тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшин тогтоох үйл ажиллагааг зохицуулах журам”, “Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, “Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар /КОВИД-19/ илэрсэн объектыг хамгаалтанд авах түр журам”-уудыг мөрдүүлж, хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах алба болон мэргэжлийн анги, сумдын Засаг дарга нарт үүрэг өгч ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 12 дугаар тушаалаар иргэн, хуулийн этгээдээс хандиваар өгсөн дахин угааж хэрэглэх боломжтой даавуун амны хаалтаас 12000 ширхэгийг хөдөөгийн 16 сумын ерөнхий боловсролын сургууль, Жаргалант сумын 7 сургуульд нэг удаагийн 8000 ширхэг амны хаалтыг олголоо.

Зудын эрсдэлийн үнэлгээг 2021 оны 03 дугаар сарын 05- ны өдрийн дотор хийж, тайланг үндэслэн цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч хаваржилт хүндэрч болзошгүй сумдад аймгийн аюулгүй нөөцөөс өвс, тэжээл хүргэх ажлыг хуваарийн дагуу олгохоор шийдвэр гарч зохион байгуулж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/176, А/180 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг хязгаарлаж, захирамжийн хэрэгжилтийг хангуулан хяналт тавин ажиллалаа.

Улаанбаатар хот болон бусад аймгаас орон нутагт ирэх, буцах, /эрүүл мэнд буяны ажил/-тай, албан томилолт, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, өвс тэжээл, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан, зам барилга бүтээн байгуулалтын тээвэрлэлт хийх тухай хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт холбогдох бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч судалж шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу нэвтрүүлэх, зөвшөөрөл олгоход онцгой анхаарч албан бичгээр ирэх зөвшөөрөл, аймгийн Онцгой комиссын тусгай зөвшөөрлөөр иргэн, тээврийн хэрэгслийг гаргаж шуурхай шийдвэрлэж ажиллав.

Улаанбаатар болон өөр аймгийн нутгаас ирж байгаа иргэдээс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Дарви сумын хяналтын цэгт түргэвчилсэн тестээр шинжилгээг тогтмол авч ажиллаж байна. Улаанбаатар хот болон өөр аймгаас иргэдээ татан авах үйл ажиллагаатай холбогдуулан Дарви сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шаардлагатай үед иргэдийг тусгаарлан ажиглах байр болгон бэлтгэж иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулан хяналт тавин ажиллаж байна.

Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 38 өргөдөл бичгээр хүлээн авч, 25 өргөдлийг шийдвэрлэж, 13 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 4 өргөдлийг шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 65.9 хувьтай байна.

Засгийн газрын 1111 төвд тайлант 3 дугаар сард гомдол 1 ирж хугацаанд нь шийдвэрлэв.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 17 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 14, биечлэн 3 санал хүсэлт ирүүлснээс гомдол 1, санал хүсэлт 13 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 16 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 94.2 хувьтай байна. Үүнд хууль эрх зүй 1, орчны эрүүл ахуйн асуудлаар 6, Эрүүл мэндийн асуудлаар 3, цахилгаан эрчим хүчний асуудлаар 1, бусад асуудлаар 6 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 16, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа гомдол 1 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 3 дугаар сард улсын төсвийн санхүүжилтээр 14819.3 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 825.5 сая төгрөгийн санхүүжилтээс 538.3 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 3897.5 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 1882.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 6674.9 сая төгрөг, цэцэрлэг 3465.5 сая төгрөг, хүн эмнэлэг 1765.2 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 123.0 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 133.1 сая төгрөг тус тус олгосон.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа байгууллага /Эрүүл мэнд, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Гааль болон төрийн тусгай чиг үүргийн/-аас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой бүх байгууллага, аж ахуйн нэгжийн 2021 оны төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэн Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 5/485 дугаар албан бичгээр төсвийн захирагч нарт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан биелэлтэнд төрийн сан болон ажил хариуцсан албан тушаалтнуудаас тавих хяналтыг эрс дээшлүүлж, хариуцлагыг сайжруулж ажиллахыг анхааруулан хэрэгжүүлж байна.

Нягтлан бодогчдод санхүүгийн тайланг хуулийн хугацаанд боловсруулан И-тайланд шивүүлэхэд анхаарч, зөвлөгөө өгч ажилласнаар 2020 оны жилийн эцсийн 224 тайлан нэгтгэхээс 205 санхүүгийн тайланг авсан нь 91,5 хувьтай байна.

Аж ахуйн нэгжийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулж аргагүйгээр ханган ажиллаж, нийт 1848 аж ахуйн нэгж байгууллагын тайлан хүлээн авахаас 1589 тайланг авч баталгжуулсан нь 86.0 %-тай байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 1244 ширхэг зардлын ваучер бичиж, 6777,4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж ажиллав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогчдод мессежээр, Байгууллагуудын зарлагын гүйлгээг “GFMISTOOLS” програмаар гүйцэтгэж сарын эцэст гүйлгээ хийх үеэр системийн ачаалал үүсэж байгаа тул сумдад гүйлгээ хэрхэн хийх талаар заавар зөвлөгөө өгч байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дөргөн, Буянт сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийлээ.

Дөргөн суманд хийсэн шалгалтаар нийт сумын хэмжээнд 78 иргэн, байгууллагатай холбоотой 113,4 сая төгрөгийн зөрчил илэрч, 99,4 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөн, зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгч, 13,6 сая төгрөгийн төлбөрийг аймгийн орон нутгийн төсөвт оруулахаар, 361,5 мянган төгрөгийг нөхөн олгуулахаар, Улсын ахлах байцаагчийн 18 акт тогтоолоо.

Аймгийн Прокурорын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулсаны хүрээнд Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч нарын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хуулийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, шүүхэд актын төлбөрийг нэхэмжлэх зэрэг зарим тулгамдаж буй асуудлуудаар мэдээ мэдээлэл хүргэж, уулзалт, ярилцлага зохион байгуулж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлээ.

Аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны жилийн эцсийн хувь хүний орлогын албан татварын тайланг хүлээн авч нэгтгэх ажлын хэсэг томилж, 15347 иргэн, НӨАТ-ын тайланг 98,9 хувьтай хүлээн авсан.

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн газартай тулгалт хийж Тахаст болон Tips програмд бүртгэж компани 61, нөхөрлөл 6, төрийн бус байгууллага 10, салбар 1, хоршоо 3 нийт 80 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдсэн мэдээтэй байна.

2021 оны 03 сарын 29-ны байдлаар улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 4604,8 сая төгрөг оруулахаас 3193,6 сая төгрөг орсон нь 69,3 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 1152,2 сая төгрөг оруулахаас 924,2 сая төгрөг оруулсан нь 80,2 хувийн, аймгийн төсөвт 2936,8 сая төгрөг оруулахаас 1834,6 сая төгрөг оруулсан нь 62,6 хувийн, сум орон нутгийн төсөвт 521,7 сая төгрөг оруулахаас 434,6 сая төгрөг оруулсан нь 83,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дөрөв: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хууль эрх зүйн хэлтэс нь 1 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 1 иргэнд анхан шатны баримт бичиг боловсруулж тусламж үзүүлэв.

Шүүх хуралдаанд 4 удаа оролцож, шүүхэд нотлох баримт 3 удаа бүрдүүлж өгсөн. Мөн Чандмань, Эрдэнэбүрэн сумдын 31 баримтын Засаг даргын захирамж болон төсөвт байгууллагуудын дарга нарын тушаалын хууль зүйн үндэслэлийг хянаж байна.

Архивын тасгаас тайлант сард Ховд Их Сургуулийн дотоод ажил хариуцсан 15 хүн, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-аар сургалт зохион байгуулж, 1975-1998 оны 3 хөмрөгийн 3 дансны 37 хадгаламжийн нэгж буюу 3592 хуудсыг цахим хэлбэрт шижүүллээ.

Архивын лавлагааг 24 хүнд олгосноос 5 хүнд тушаал, 14 хүнд цалингийн тодорхойлолт, 5 хүнд мал тооллогын лавлагаагаар үйлчилсэн.

Цагдаагийн газар: Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2021 оны 3 дугаар сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Орон нутгийн зам-Хяналт шалгалт", "Автомашинны гадна талын

гэрэлтүүлэх хэрэгсэл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, 1530 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 1146 зорчигчид холбогдох хууль тогтоомжоор бэлтгэсэн гарын авлага, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тараан өгч, яриа таниулга хийв.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Би байна” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, цагдаагийн газрын цахим хуудас болон нийт алба хаагчдын фэйсбүүк хаягны фрэйм /хүрээ/-г “Би байна” арга хэмжээний логогоор солиулж, цагдаагийн газрын даргын тушаалаар /аж ахуйн нэгж, байгууллага хариуцах тухай/ алба хаагчид хуваарилагдсан 103 байгууллага бүрийн дарга, эрхлэгч, ажилтнуудад “Би байна” нэгдсэн арга хэмжээнд ажилтнуудынхаа хамт нэгдэх талаар уриалж, хувийн фэйсбүүк хаягны фрэйм /хүрээ/-г арга хэмжээний логогоор солиулах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг зохион байгуулж, 24 захидал ирснээс 2 байрыг шалгаруулав. Цагдаагийн газрын алба хаагчдыг оролцуулсан “Ээждээ хэлэх үг” нэвтрүүлгийг бэлтгэн, Ховд телевиз болон цагдаагийн газрын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэлээ.

Сум, багийн хэсгийн мөрдөгч, байцаагч, цагдаа нар хариуцсан нутаг дэвсгэрийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгааг тухай бүр шинэчилж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчлийн хэргийн холбогдогчийн мэдээллийг цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсний субъектын бүртгэлийн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн бүртгэл”-д бүртгэн, хяналт тавьж ажиллав. Бүртгэлд авсан этгээдүүдээс гэр бүлийн хүчирхийлэл дахин үйлдээгүй болно.

Сумдын “Олон нийтийн цагдаа нарын сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, оролцогчдод гарын авлага, сургалтын материалыг тараан өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан. Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн холбогдох заалтаар 2 төрлийн зурагт хуудас бэлтгэн, аж ахуйн нэгж байгууллага болон олон нийтийн газар, худалдаа үйлчилгээ төвүүдийн мэдээллийн самбарт 200 ширхэгийг байршууллаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийллийн талаар 2 кейс дээр “Хүүхдийн хууль зүйн хороо”-г хуралдуулж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авлаа.

Ховд аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар нийт 278 гомдол мэдээлэл хүлээн авсны 50 буюу 17,9 хувийг гэмт хэргийн шинжтэй, 228 буюу 82,0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн 33 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 1, хулгайлах гэмт хэрэг 4, залилах гэмт хэрэг 3, хөрөнгө завших гэмт хэрэг 1, эд хөрөнгө устгах, гэмтээх 1, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг 4, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг 3, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн байна.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 132 хүнийг эрүүлжүүлж, зөрчил гаргасан 243 хүнийг 50,435,000 төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 85 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 38 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж ажиллав.

Шүүхийн шинжилгээний алба: Тус алба нь жуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 11 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 88, хавтаст хэрэг 2, тусгай шинжилгээ 22, криминалистикийн шинжилгээ 9 тус тус хийж дүгнэлт гаргав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 21 мөрдөн байцаалтын туршилт болон бусад ажиллагаанд 14 удаа тус тус оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 6 ширхэг, гутлын мөр 11, тээврийн хэрэгслийн мөр 7, биологийн гаралтай ул мөр 3, эвдлэгч багажны мөр 3, бусад ул мөр, эд мөрийн баримт 21 илрүүлж бэхжүүлэн авч гэрэл зургийн ажил 621 гарын мөрний санд гарын дардас 20, гарын мөр 5 авч баяжилт хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард нийт 2982 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1526, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 400 ба шилжин ирсэн иргэд 73, аймаг доторх сумаас суманд 176, багаас багт шилжсэн 151, гадаад паспорт олголт 73, иргэний үнэмлэх

шинээр олгосон 52, сунгалт 103, дахин олгосон 63, иргэний бүртгэлийн лавлагаа 580 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 255 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 1323, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 123 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Иргэдээс нийт 10 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 5 шийдвэрлэж, хугацаа болоогүй 5 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хүлээгдэж байна.

Тав: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: БШУЯ болон түүний харьяа БМДИ, БХ, БҮ-ний төвөөс зохион байгуулсан 5 удаагийн цахим уулзалт, зөвлөгөөнд БСУГ-ын дарга, мэргэжилтэн, сургууль, цэцэрлэгийн удирдлагууд оролцож цар тахлын улмаас танхимын сургалт түр зогссоноос үүдэлтэй сургалтын хөтөлбөрийн тасалдалыг арилгах, боловсролын салбарын хөгжлийн бодлого, шуурхай шийдвэрлэх асуудлуудаар чиглэл авч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу 3 дугаар сарын 1-ээс аймаг сумдын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг танхимаар хичээллүүлэх болсонтой холбогдуулан БШУ-ны сайдын А/58 тоот тушаалыг болосролын бүх шатны байгууллагуудад мөрдүүлэн, анги бүлгийн хүүхдийн тоог багасган дэд бүлгүүдээр хуваарилан 2-4 ээлжээр хичээллэж байна.

Орон нутгийн сургууль, цэцэрлэгийн удирдлагуудын цахим хурлыг 3 удаа зохион байгуулж боловсролын болон орон нутгийн удирдах байгууллагуудын шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шуурхай удирдлага, зөвлөмж өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн газартай хамтран “Ковид-19 халдвараас сэргийлэх, хянахад анхаарах асуудал” сэдэвт мэдлэг олгох зорилго бүхий онлайн сургалтыг сургууль цэцэрлэгийн эмч нарт 3 дугаар сарын 01-нд зохион байгуулж, 30 эмч хамрагдлаа. Сургалтаар эмч нарт тулгамдаж буй асуудал, ариутгал цэвэрлэгээ, халдвараас урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдээлэл хийж, харилцан ярилцлага өрнүүллээ. Мэдээллийг цэцэрлэг, сургуулийн цахим группэд байршуулж нээлттэй түгээж байна.

БШУЯ-аас 3 дугаар сарын 3-нд сургууль цэцэрлэгүүдийн удирдлага, эмч нарт зохион байгуулсан “Халдварт өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах” арга зүйн цахим сургалтад нийт 58 байгууллагын 180 хүн оролцлоо. Сургалтаар “Коронавируст халдварын үед ЕБС-ийн хичээл эхлэх бэлэн

байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах”, “Ковид 19-ийн үед хичээл эхлэхтэй холбоотой цэвэрлэгээ, халдваргүйтгэл, агааржуулалтыг хэрхэн сайжруулах вэ?”, “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хичээл эхлүүлэх бэлэн байдлыг хангах нь” гэсэн сэдвийн хүрээнд зохион явагдсан.

Багшийг ажлын байранд хөгжүүлэх зорилгоор монгол хэл, уран зохиолын багш нарыг чадваржуулах, онол, хүндэвтэр агуулгыг заах арга зүйн онлайн сургалтыг 02 дугаар сарын 26-27-нд 2 өдрийн сургалтыг Монгол Улсын зөвлөх багш Ц.Марттай хамтран амжилттай зохион байгууллаа. Сургалтад монгол хэл уран зохиолын 81 багш хамрагдлаа.

Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийг теле болон цахим хичээл, танхимын хичээлийн аль алинд нь ашиглаж болох сайжруулсан жилийн төлөвлөлт болон нэгж хичээлийн төлөвлөлт боловсруулах арга зүйн сургалтыг онлайнаар зохион байгуулж, 62 багш хамрагдлаа. Багш нар сургуулиараа баг болон аймгийн хэмжээнд жишиг төлөвлөлт хийхээр ажиллаж байна.

Японы хүүхдийг ивээх сантай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдтэй ажиллах арга зүйн сургалтыг сургуулийн захирал, сургалтын менежерүүд, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарт онлайн хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтад 24 захирал, 24 сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 60 хүн хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах мэдлэг ойлголтоо сайжруулсан.

Анги танхимд хэрэгжүүлж болох 172 шинэлэг санаа сургалтыг 3 дугаар сарын 5-нд зохион байгуулж, бага ангийн 66 багш хамрагдлаа. Сургалтыг МУБИС-ийн “Хүүхдийн хөгжлийн төв”-ийн эрхлэгч Д.Одгэрэл, судлаач Н.Оюунтунгалаг, 63 дугаар сургуулийн сургалтын менежер Ц.Мөнхцэцэг багш нарын үндэсний сургагч багш нар зохион байгуулсан.

БШУЯам, Дэлхийн Зөн Монгол ОУ-ын байгууллагатай хамтран “Ерөнхий боловсролын сургуулийн цогц аюулгүй байдал” олон улсын санаачилгыг түгээн дэлгэрүүлэх 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, сэтгэлзүйч, дотоод хяналтын ажилтан, цэцэрлэгийн эмч, арга зүйч нарыг бүрэн хамруулж, сургалтад 58 байгууллага оролцлоо.

Хүмүүжлийн эерэг арга сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 34 цэцэрлэгийн арга зүйч, заах аргын нэгдлийн ахлагчид оролцож байна. Үүний үр дүнд бүх цэцэрлэгийн багш, эцэг эхчүүдэд сургалт зөвлөгөөг хүргэж, хүүхэд бүр сурч, хөгжих эрх хангагдах ач холбогдолтой юм.

СӨБ-ын эрхлэгч, арга зүйч, багш нарын онлайн сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Говь-Алтай аймгийн СӨБ-ын мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж, 80 цэцэрлэгийн 400 гаруй хүн хамрагдлаа. Уг сургалтад хамрагдсанаар сүүлийн үед хэрэгжүүлж буй тушаал шийдвэрийн биелэлт болон хэрэгжилтийг хангах, онол арга зүйн мэдлэгээ нэмэгдүүлсэн нь ач холбогдолтой байлаа.

2020-2021 оны хичээлийн жилд ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд судлагдахуун бүрээр сорилыг авч байгаа бөгөөд тайлант сард нийт 7 судлагдахуунаар сорил авч давхардсан тоогоор 1804 сурагч хамрагдсан байна.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж буй мэргэжлийн бүлгийн хэлэлцүүлгийн хүрээнд “Ахлах ангийн математикийн цахим хичээл” боловсруулах ажлыг зохион байгуулж, тус багш нарын 5 удаагийн видео хичээл, дагалдах хэрэглэгдэхүүн, үнэлгээний даалгавар зэргийг боловсруулан иж бүрэн цогц нэгж сэдвийн хөтөлбөр боловсрууллаа.

СӨБ-ын бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн багш нарын дунд зохион байгуулсан 2-3 сарын аяны явц, цаашид хийх ажлын арга туршлага солилцож, хэлэлцүүлэг зохион байгуулж, 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж, төрийн бус өмчийн 10 цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан, хүүхдийн ирцийг авч, багш, эрхлэгчдэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Түүнчлэн төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд зөвлөмж боловсруулан, 2021 оны 3 дугаар сарын 17-ны А/77 албан тоотой хүргүүлээ.

Хөгжмийн багш нарыг чадваржуулах, цахим хичээлийн сан бүрдүүлэх зорилгоор 34 багш өөрсдийн сонголтоор хоцрогдсон агуулгаар 20 гаруй цахим хичээл боловсруулан, багш нарын группэд байршууллаа. Энэ хүрээнд багш нартайгаа онлайн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгууллаа.

Соёл, урлагийн салбарын үйлчилгээний болон орчны стандартыг сайжруулан, хүний нөөцийг чадваржуулж, олон угсаатны соёлын өвийг хадгалан хамгаалах,

өвлүүлэх, хөгжүүлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Олон үндэстэн ястны өв, соёл урлаг” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан хэлэлцүүлгийг соёл, урлагийн байгууллагын ажилчид, соёл урлагийн зүтгэлтэн, судлаачид, соёл урлагийн чиглэлийн мэргэжлийн холбоодуудын дунд 3 удаа нээлттэй хэлэлцүүлээ.

Аймгийн Нийтийн номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх, эх хэл, түүх соёлыг өвлүүлэн уламжлуулах, стандарт орчинг бүрдүүлэн материаллаг баазыг сайжруулж, хүний нөөцийг чадваржуулах сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж, уялдаа холбоог сайжруулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор “Оюунтүлхүүр” дэд хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгууллаа. Тус 2 дэд хөтөлбөрийн төслийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.

Аймгийн хэмжээнд 25 сургуулийн нийт 78829м², 33 цэцэрлэгийн 41004м² талбайд мэргэжлийн байгууллагын зөвлөмжөөр ариутгал цэвэрлэгээ хийж, ариутгал халдваргүйжилтийн мэдээг нэгтгэн аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлээ

ОХУ-ын Засгийн газрын 2021-2022 оны тэтгэлгийн шалгаруулалтад аймгаас 12 дугаар анги төгсөх 38 сурагч бүртгүүлсэн, шалгаруулалтын дүн 2021 оны 04 дүгээр сарын 5-ны өдөр гарахаар хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловсролын салбарт хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжлийн боловсрол", "Чадварлаг багш, оюутан, сурагч", "Монгол хэл, бичиг", "Чанартай боловсрол" дэд хөтөлбөрүүдийн хэлэлцүүлгийг Жаргалант сумын ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөгжил политехник коллеж, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Ховд их сургууль, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн зэрэг олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хэвлэл мэдээллийн төлөөлөл нийт 130 гаруй оролцогчдыг хамруулан зохион байгуулж, санал солилцов. Хөтөлбөрийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж, хөтөлбөрийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийн тооцоо хийгдэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Эх түүхийн боловсролыг бүх нийтэд” уриан дор “Өөрийн нутаг ус, түүхэн домог, аман яриа” аяныг 2 дугаар сарын 22-ноос 3 дугаар сарын 14 хүртэл зохион байгуулан явууллаа. Аяны хүрээнд 19 сургуулийн 71 сурагчаас ирсэн домог түүх, аман яриаг “Түүхийн багш” пэйж хуудсаар түгээж нээлттэй мэдээлж байгаа төдийгүй Жаргалант

сумын түүх нийгмийн ухаан, монгол хэлний багш нар хамтран аман яриа домог түүхүүдийг кирилл болон монгол бичигт хөрвүүлэн эмхэтгэж гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн болгохоор ажиллаж байна.

Боловсролын салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор боловсролын удирдлагын мэдээллийн систем ашиглан багш нар, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургалтын менежерүүдээс санал асуулга авсан. Эдгээр санал асуулгад СӨБ-ын 349, ЕБС-ийн 1150 багш удирдах ажилтан хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулиудын 2021 оны цалингийн сангийн дутагдлын тооцоо судалгааг гарган Боловсрол, Шинжлэх ухааны сайдад уламжлав. Жилийн нийт дүнгээр 1782,0 сая төгрөг дутагдах тооцоо гаргаж хүргүүллээ.

Төсвийн хуваарийн дагуу 3 дугаар сарын санхүүжилтийг батлагдсан ЕБС 4 401,8 сая төгрөг, СӨБ 100,2 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн сард олгов. Мөн хувийн цэцэрлэгүүдийн санхүүжилтийг 3 дугаар сарын хүүхэд өдрийн гүйцэтгэлээр олгосон.

Боловсролын мэдээллийн системд 27 сургууль, НТБ, 44 төрийн болон хувийн цэцэрлэгүүдийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, хөрөнгийн мэдээллийг оруулахад хяналт тавьж, Жаргалант сумын сургуулиудын сурагчдын ширээ, сандал нийлүүлэх 35 сая төгрөгийн өртөгтэй ажлын даалгавар боловсруулж, нээлттэй тендер шалгаруулалт зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлээд байна.

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5, 42.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор БШУЯ-аас боловсролын салбарын хэмжээнд газар эзэмшил, ашиглалт, барилгын асуудлаар судалгаа хийж дүгнэлт гаргахаар болсон. Иймээс аймгийн бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд өөрийн байгууллагын газар эзэмшилт, ашиглалт, барилгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт маягтын дагуу нэгж байгууллагаас авч, мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран хянаж, /сургууль, цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн газар/ нэгтгэлийг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр БШУЯ-ны мэргэжилтний sansarodma@gmail.com цахим хаягаар мөн аймгийн ЗДТГ-т хүргүүллээ.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тайлант сард товллын вакцинжуулалтын хүрээнд сүрьеэгийн эсрэг вакцинд 155 хүүхэд, В гепатитийн эсрэг вакцинд 154, Халдварт саагийн эсрэг вакцинд 656 хүүхэд, халдварт саагийн идэвхгүйжүүлсэн вакцинд 175 хүүхэд, Тавт вакцинд 499 хүүхэд, Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг вакцинд 289 хүүхэд, А гепатитийн эсрэг вакцинд 273 хүүхэд, Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилгад 481 хүүхэд тус тус хамруулж хамралтыг 99.4 хувьтай гүйцэтгэж, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины нэмэлт дархлаажуулалтанд 2016-2018 онд төрсөн 5410 хүүхдийг хамруулахаас 4771 хүүхдийг хамруулж 88.2 хувьтай гүйцэтгэлээ.

Дарви сумын Булаг багийн "Усан хар" гэдэг газар малчин Б 69 нас эрэгтэй ирвэсэнд хазуулсан дуудлагыг Зооноз өвчин судлалын төвөөр гүйцэтгүүлэн галзуу өвчнөөс сэргийлэх вакцины эхний тунг тухайн өдөр хийлгэж, үлдсэн тунг вакциныг Дарви сум руу хүргүүлэн үлдсэн тунг хийж, хяналт тавьж ажиллахыг зөвлөв.

Ковид-19 халдварын голомтот бүс нутгаас ирсэн 2383 иргэнийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийг хүргэж гэрийн ажиглалтанд хяналт тавин ажиллаж, Увс аймгаас Ховд аймагт ирсэн 14 хүн, Зэрэг сумаас шалтгаан тодорхойгүй 5 хоног халуурсан хүн 2 хүнийг тусгаарлалтанд авч 2 иргэнд түргэвчилсэн тест тавьж, Аэромонголия онгоцоор ниссэн 22 зорчигчыг ПГУ шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахад бүгд сөрөг гарлаа.

Аймгийн БОЭТ-д 3 сарын 14-ний өдөр тоног төхөөрөмж угсарсан Улаанбаатарын 2 иргэнээс УБ хотод коронавирусын халдвар авсан нь батлагдсан тул шинжилгээнд хамруулах иргэдийн нэрс гэрийн хаяг зэргийг авч гэрээр нь очиж хамар залгиурын арчдас, ам залгиурын арчдас цуглуулж 1-р хавьтлын 20 хүн, 2-р хавьтлын 63 хүн, Талын буудалд тухайн өдөр ажиллаж байсан 6 хүний ар гэрийн 16 хүн, ээлж солилцсон талын буудал зочид буудлын 10 ажилтан, БОЭТөвийн 160 хүн нийт 249 хүнийг тогтоож, 2 удаагийн ПГУ шинжилгээнд хамруулж сөрөг гарсан тул гэрийн тусгаарлалтад шилжүүлж, "Талын буудал" зочид буудалд 600м² талбайд халдваргүйжүүлэлт хийж ажиллав.

Өвөрхангай аймгийн Хужирт сумын Сэмжин Хужирт Рашаан сувилалд 3 дугаар сарын 14-21-ний хооронд Ховд аймгийн иргэн амарсан. Тус Сэмжин Хужирт Рашаан сувилалд Коронавируст халдвар /ковид-19/ гарсан тухай Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газраас мэдээлэл өгч уг иргэнийг гэрт нь тусгаарлан 2 удаа ПГУ

шинжилгээнд хамруулахад сөрөг гарсан. Тус иргэнийг үргэлжлүүлэн тусгаарлан хяналт тавин ажиллаж байна. Тайлант 3 дугаар сард PCR шинжилгээг 1107, хурдавчилсан оношлуураар 3287 иргэнд шинжилгээ хийв.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс улирлын томуугийн вакцины зардал, үр ашгийн судалгааг 10 аймаг, 7 дүүргийн хэмжээнд зохион байгуулж аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчнөөр өвдөж амбулатори болон эмнэлэгт хэвтсэн гэх шалгуурын дагуу 0-5 насны 60 хүүхэд, жирэмсэн 40, 65-аас дээш насны 40, нийт 140 судалгааг авах ажлыг зохион байгуулан ажиллаж асуумж 72 хувьтай явагдаж байна.

Урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн чиглэлээр эхний 3 сарын байдлаар ХДХВ, тэмбүүгийн шинжилгээнд 3768 хүн хамрагдсанаас 31 тэмбүүгийн халдвартай хүн шинээр оношлогдсоны 8 жирэмсэн эх шинээр тэмбүү өвчнөөр оношлогдож хавьтлын хамт эмчилгээнд хамрууллаа. Бэлгийн замын дамжих халдварыг илрүүлэх шинжилгээг БОЭТ, Булган сумын Нэгдсэн эмнэлгээс гадна 9 /Дуут, Мөст, Чандмань, Үенч, Цэцэг, Мөнххайрхан, Дарви, Зэрэг, Манхан/ сумын эрүүл мэндийн төвүүд грамын болон нойтон түрхэцийн аргаар наацийн шинжилгээ хийж наацийн шинжилгээгээр трихомониаз 8, заг хүйтэн 9 оношлогдож хяналтанд авч эмчилж байна.

Сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийг Алтай, Ховд, Цэцэг сумууд нийт 7 хүний сүрьеэгийн сорьц тээвэрлэж, бусад сумд сүрьеэгийн сорьц тээвэрлээгүй бөгөөд эхний 3 сард сүрьеэгийн 3 халдварын тохиолдол шинээр бүртгэгдэж сүрьеэгийн диспансерт хяналтанд авч эмчилгээг эхлүүлээ.

2018-2021 онд сүрьеэгээр өвдсөн иргэдийн судалгааг сум тус бүрээр гаргахад нийт 16 суманд 84 сүрьеэгийн өвчлөл бүртгэгдсэн бөгөөд хамгийн өндөр өвчлөлтэй сумд Булган, Манхан байна. Уг 84 сүрьеэгийн өвчлөлийн өрхийн болон ойрын хавьтлын судалгааг сум тус бүрээр гаргаж хавьтлуудыг 2021 оны 3 дугаар сарын 29-нээс 4 дүгээр сарын 29-ний хооронд БОЭТ-д шинжилгээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Жил бүр “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг 3 дугаар сарын 24-нд тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил “Цаг явсаар байна” уриан дор тэмдэглэж цахим сурталчилгааны материалуудыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж цахимаар иргэдэд мэдээлэл өгч, сүрьеэгийн диспансертэй хамтран хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгчдэд 3 төрлийн давхардсан тоогоор 200

ширхэг зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, яриа таниулга хийж, ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгч, орон нутгийн Ховд телевизээр сүрьеэгийн халдвараас сэргийлэх талаар Сүрьеэгийн диспансерийн эрхлэгч эмч Б.Оюунцэцэг мэдээлэл өгсөн.

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээний тайланг нэгтгэхэд артерийн даралт ихсэлтийн илрүүлэг үзлэгт 3587, чихрийн шижингийн илрүүлэг үзлэгт 2780, сүрьеэ өвчний илрүүлэг үзлэгт 408, элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 2566, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 50, ходоодны хорт хавдрын илрүүлэг үзлэгт 314, хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 2710, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэгт 437, түрүү булчирхайн хорт хавдрын илрүүлэг үзлэгт 59 хүнийг тус тус хамрууллаа.

Сумын эрүүл мэндийн төвүүдийн лаборант нарын серологийн шинжилгээ болон наацийн шинжилгээ хийх мэдлэг, ур чадварыг дээшүүлж тэмбүү, бэлгийн замаар дамжих халдварт өвчний үүсгэгчийг эрт үед илрүүлж, оношлох чадавхийг бэхжүүлэх зорилгоор 3 сард Алтай, Дөргөн, Булган сумын нэгдсэн эмнэлэг, Мянгад, Дарви сумын Эрүүл мэндийн төвийн лаборант нарыг дагалдуулан сургаж чадавхижууллаа.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалт судалгааны албатай хамтран 2021 оны 3 сарын 25-ны өдөр БОЭТ, сум, өрхийн эх барих, нярай, хүүхдийн эмч нарт “Эхээс хүүхдэд тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох нь” сургалт, “Эрүүл хооллолт” сургалтуудыг цахимаар зохион байгуулснаас гадна “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” арга хэмжээг Биеийн тамитр спортын газартай хамтран 447 гишүүнтэй оролцож 710 км гүй оролцлоо.

БОЭТ, сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2021 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгсэл нийлүүлэх тендер худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу tender.gov.mn цахим системээр дамжуулан 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зарлаж, нээлт 3 дугаар сарын 31-ний өдөр орон нутгийн цагаар 10 цаг 20 минутад болохоор төлөвлөгдөөд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2021 оны 01 дүгээр улирлын хурлыг зохион байгуулж, нийт 25 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэв.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 сарын 611 тоот тушаалын дагуу 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэгийн маягтыг хүүхэд нэг бүр дээр хөтлөх зорилгоор сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авсан 3 хүртэлх насны хүүхдийн судалгаагаар 4234 хүүхэд хамрагдахаар байна. Тайлант сард аймгийн нийт үзлэг 64179, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 15119 буюу нийт үзлэгээс 23,5 хувийг эзэлж байна. Нийт төрөлт 2 дугаар сарын байдлаар 330 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн энэ үеэс 9 тохиолдлоор нэмэгджээ.

Нялхсын эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 9 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 2,8 промилээр буурсан, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 9 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 8,6 промилээр тус тус буурсан, халдварт өвчин 59 тохиолдол буюу өмнөх оны мөн үеээс 39 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн өвчлөл 66, осол гэмтлийн нас баралт 10 бүртгэгдсэнээс нийт өвчлөлийн 68.2 хувийг эрэгтэй, 31,8 хувийг эмэгтэй хүйсийн иргэд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS програмд 2021 оны 3 сарын 23-ны өдрийн байдлаар ажил хайгч иргэд 1866, үүнээс 888 эмэгтэйчүүд байна. Тайлант сард нийт 181 иргэнийг шинээр бүртгэж, идэвхгүй жагсаалтанд байсан 260 иргэний мэдээллийг шинэчилсэн. Шинээр бий болсон 155 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS програмд шивлээ.

Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 321 ажлын байрны захиалга авч, 262 иргэнийг ажлын байранд зуучилсан, Үүнээс байнгын ажлын байранд 97, улирлын ажлын байранд 141, түр ажлын байранд 24 иргэн зуучлагдсан.

Covid -19 цар тахлын улмаас ажил хайгч иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахимаар бүртгэн ажиллаж байна. 3 дугаар сарын байдлаар ажил хайгч 35 иргэн цахимаар бүртгүүлсэн байна. Сургалтанд хамрагдах хүсэлтэй 205 иргэнийг ажил хайгчаар бүртгэж зөвлөгөө мэдээлэл өгч, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөг 127 иргэнд үзүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 59 иргэнтэй утсаар холбогдон ажлын байр санал болгож 21 иргэнийг Гэрэлт Манхан ХХК, Ховдын өргөө ХХК-д ажлын байранд зуучиллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Covid-19 цар тахлын үед ажлын байранд аюулгүй ажиллах, халдвараас ажилтны эрүүл мэндийг хамгаалах нь” ISO/PAS 45005:2020 стандартын сургалтыг цахимаар зохион байгуулж аймгийн 10 аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтан, ХАБЭА хариуцсан ажилтнуудыг хамрууллаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамжийн санд 40 000 000 төгрөг, Улсын төсвөөс Халамжийн тэтгэвэрт 1 034 000 000 төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 555 000 000 төгрөг, Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 265 000 000 төгрөг, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжид 221 392 000, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжид 102 000 000 төгрөг, Хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид 323 224 000 төгрөг, Банкны шимтгэлийн санхүүжилт 1 800 000, Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулалд 5 712 000 нийт 2 548 128 000 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагаа хэвийн байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд аймгийн хэмжээнд 2021 оны 3 дугаар сарын байдлаар 35211 хүүхдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулсан ба шинээр төрсөн 439 хүүхдийн мэдээллийг бүртгэлээ. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 1502 өрхийн 4579 том хүн, 3905 хүүхдэд 104.504.000 төгрөгийн төсөв зарцуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2021.03.10-ны өдөр хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 18 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа.

Халамжийн тэтгэвэрт шинээр хамрагдсан болон сунгалт хийлгэсэн 51 иргэний мэдээллийг баримтын бүрдэлтэй нь тулгаж халамжийн нэгдсэн системд баталгаажуулалт хийлээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний эрх авсан “Ачлалт наран хайрхан ХХК” -ны “Ивээл” эмнэлэгтэй хамтарч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд “Сэргээн засах үйлчилгээ”-г үзүүлж нийт 20 хүүхдийг хамрууллаа.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 4058 даатгуулагчийн 336587,0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 2956 даатгуулагчийн 162834.9 мянган төгрөгийн орлого, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 803 ажил олгогчийн 12154 даатгуулагчийг хамруулж нийгмийн даатгалын санд 4497388.5 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлээ. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 9688 иргэнд 11115.8 сая, тахир дутуугийн тэтгэвэр авагч 1614 иргэнд 1507.7 мянган төгрөг, тэжээгчээ алдасны тэтгэвэр авагч 662 иргэнд 641.2 мянган төгрөг, цэргийн алба хаасны тэтгэвэр авдаг 307 иргэнд 639.3 мянган төгрөг Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тахир дутуугийн тэтгэвэр авагч 39 иргэнд 48.8 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус олгоод байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас: Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 355 даатгуулагчид 55555.1 мянган төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 171 даатгуулагчид 249116.7 мянган төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид шинээр 91 хүн давхардсан тоогоор 292 даатгуулагчийн 182363.5 мянган төгрөг, 68 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 68 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

ЭХМК-с нь 03 сард 3 удаа хуралдаж нийтдээ 136 иргэний ХЧА-н асуудал хэлэлцэн шийдвэрлэж 25 иргэнд шинээр ХЧА-т тогтоож, 107 иргэний ХЧА-ыг сунгаж, 4 иргэний ХЧА-г цуцлаж мэдээллийн баазад 2966 иргэн бүртгэлтэй байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөнд нийт 4 насанд хүрэгч 4 хүүхэд хамрагдсан. Хандсан шалтгаанаар авч үзвэл гэр бүлийн харилцааны зөрчил-3, гэр бүлийн хүчирхийлэл-1, мэргэжил сонголт-2, дэлгэцийн хамаарал-1, сэтгэл гутрал-1 байна. Зөвлөгөөнд хамрагдсанаар учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэрхшээлийг даван туулах чадвар нь нэмэгдэж байна. 2021 оны эхний 3 сарын байдлаар хүүхдийн эрх зөрчигдсөн болон гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 43 гомдол мэдээлэл хүлээн авч хариу үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

2021 оны 03 дугаар сарын байдлаар хүүхдийн тусламжийн 108 утсанд 25, бичгээр 12 нийт 37 гомдол мэдээлэл бүртгэгдсэн. Бие махбодын хүчирхийлэлд өртсөн 3 хүүхэд, бэлгийн хүчирхийллийн шинжтэй 2, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 9, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 6 иргэн бүртгэгдсэн. Эрх нь зөрчигдсөн хамгаалал шаардлагатай 07 сартайгаас 17 насны 20 хүүхэд, гэр бүлийн

хүчирхийллийн 19-48 насны 4 насанд хүрэгч үүнээс эрэгтэй 5, эмэгтэй 19 нийт 24 хүнд хариу үйлчилгээ үзүүлсэн.

Хамтарсан багт шилжүүлсэн 7 гомдол мэдээлэл, нөхцөл байдлын үнэлгээг 10 гэр бүлд хийж, хүүхдийн эрсдэлийн үнэлгээг 8 хүүхдэд, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээг 3 гэр бүлд, аюулгүй байдлыг хангах үйлчилгээг 10 иргэнд, дэмжих үйлчилгээнд 5, гэр бүлд нь эргэн нэгтгэсэн 4, холбон зуучлах үйлчилгээнд 8 иргэнийг тус тус хамруулж, сум багийн хамтарсан багийн хурлыг 7 удаа, хүүхдийн эрхийн Хууль зүйн хороо 2 удаа хуралдав.

Хүүхдэд бие махбодын хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнд торгох шийтгэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнд баривчлах арга хэмжээ, хүүхдийн дэргэд архидан согтуурч, үл хайхрах хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнд торгох арга хэмжээ авагдсан. Түр хамгаалах байранд 10 иргэнийг 1-29 хоногийн хугацаанд байрлуулж аюулгүй байдлыг хангасан бөгөөд үйлчлүүлэгчийн хоол хүнс, ахуйн хэрэглээний зардалд 864300 төгрөг зарцуулсан.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор “Хүүхэд хамгаалалд-хамтдаа” зөвлөлдөх уулзалтыг аймгийн Прокурорын газартай хамтран зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтаар аймгийн хүүхдийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг танилцуулж, гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээг сайжруулах, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлэх талаар санал бодлоо солилцож, 2021 онд хамтарч ажиллах ажлаа төлөвлөв.

Хүүхдийн эрхийн конвенцын 5-р тайлан илтгэлд хамаарах судалгаа мэдээллийг нэгтгэж холбогдох заалтуудын биелэлт бичиж хүргүүлсэн.

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4-т заасан гэмт хэргийн хохирогч ээж, насанд хүрээгүй /3 настай/ хохирогчийн эрхийг хангах хүсэлтийг аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргаснаар шүүхээс шүүгдэгчийн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн гэм бурууд 13.6 жилийн хорих ялыг оногдуулсан анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээлээ. Хохирогчид Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хууль эрх зүй, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч 17 настай хүүхдийн асуудлаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хуралдуулж, гэр бүлийн гишүүдээс тусгаарлах хамгаалалтын арга хэмжээ авч, өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчөөр хангав. Жаргалант сумын харьяат гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бага насны 1 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэв.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээждээ захидал бичээрэй” цахим захидлын уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Хайртай ээждээ хэлж амжаагүй сэтгэлийн нандин үгээ захидлаар дамжуулан илчлэх, талархлын үгээ хэлэх боломжийг олгох зорилготой тус цахим уралдаанд 30 гаруй сурагчид оролцож ээжүүддээ өөрийн биеэр захидлаа уншиж өгч сэтгэлийн бэлэг барилаа.

Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр: Залуучууд коронавирусын эсрэг нэгдэж байна, Хүүхдийн хүчирхийллийн эсрэг гэсэн 2 шторк хийлгэж Ховд болон Олон ястны ТВ-ээр иргэдэд мэдээллээ. ШШГГ-ын 457-р нээлттэй хаалттай хорих ангид хүмүүжиж байгаа 15-34 насны хүмүүжигч болон албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд COVID-19 вирусын цар тахлаас сэргийлэх үүднээс амьдрах ухааны сургалтыг 12 модуль номоос цахим хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

“Залуучууд Коронавирусын эсрэг нэгдэж байна” залуучуудын аяны хүрээнд Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх клубын хүүхдүүд олон нийтийн газар, автобусны зогсоол, зах худалдааны төвүүд зэрэг томоохон газруудаар амны хаалтгүй явж байгаа өсвөр үе, залуучууд, иргэдэд сэрэмжлүүлэг хүргэж халдвараас урьдчилан сэргийлэх зорилготой нэг удаагийн гар ариутгал өглөө. Тус үйл ажиллагааны хүрээнд давхардсан тоогоор 10000 гаруй иргэдэд зөвлөмж хүргэж, 4000 гаруй плакат, брошур, стикер хэвлүүлж олон нийтийн газраар байршуулж Төрийн болон ТББ байгууллага, аж ахуй нэгжүүдээр дамжуулж ажилтан албан хаагч нарт нь хүргэж байна.

COVID-19 цар тахлаас сэргийлэх зорилготой улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан ном унших сонирхолтой залуучуудад цахимаар сонирхсон номыг өгч цаг хугацааг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн Залуучуудын хөгжлийн төвөөс 200 гаруй цахим номын сан ажиллуулж байна.

Зургаа: Сумдын мэдээлэл:

Дөргөн сум: Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга, багийн эмч нар 2021 оны 03 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Агваш, Сээр, Аргалант багийн

малчин өрх айлын иргэдтэй уулзаж, хаваржилтын нөхцөл байдалтай танилцаж, ОНХС-ийн хөрөнгөөр сум болон багт хийх ажлын санал асуулга авч, төр засгийн цаг үеийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны 03 сарын 04-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Шандас хэмээх газарт хяналтын пост ажиллуулж, сумаас орох гарах иргэдийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж, 12 хоногийн хугацаанд 323 тээврийн хэрэгсэл, 631 иргэн сумаас орж, гарсан хөдөлгөөнтэй байлаа.

Халдварт өвчний тархалт, хорио цээрийн үед хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд ажил хөдөлмөр эрхэлдэггүй зорилтот бүлгийн 150 өрхөд тус бүр 100000 төгрөгийн тусламж дэмжлэг үзүүлэхээр Дэлхийн зөн ОУБ-д судалгааг хүргүүлээд байна.

Ерөнхий боловсролын сургуульд үдийн цай нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах цахим системээр тендер шалгаруулалтыг нээлттэй зарлаж, 2021 оны 03 сарын 22-ны өдөр нээж, гүйцэтгэгчээр Тээлийн буян БГБХН-ийг шалгарч, гэрээ байгуулах эрх олголоо.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем egr.e-mongolia.mn системээр цахимаар тайлант 3 дугаар сард 50 албан бичиг хүлээн авч, 12 албан бичиг төлөвлөн холбогдох газарт уламжлав.

Сумын Татварын байцаагч сургалтын төлбөрийн хөнгөлөлтөнд 26, орон сууцны чөлөөлөлтөнд 9 иргэний баримт бичиг хүлээн авч холбогдох тайлан мэдээний хамт аймгийн Татварын хэлтэст хүргүүлж, шаардлага хангаагүй тайланг дахин илгээж, тайлангаа буцаан олгохоор баталгаажуулж ажиллав. Хуваарилагдсан 85 татвар төлөгчийн Хувь хүний орлогын албан татварын тайлан нэмүү өртөгийн албан татварын тайлан гаргадаг 4 аж ахуй нэгжийн тайланг хянаж илгээлээ.

Тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд газрын төлбөр 80.000төг, хог хаягдал 48.000, аж ахуй нэгжийн орлогын албан татварт 120.000 төгрөгийн нэхэмжлэл хүргүүлж татварыг төлүүлэв.

Сумын төв болон нуурийн эргэн тойронд хурсан хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн цэгт төвлөрүүлэх зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээ зохион байгуулж төсвийн 5 байгууллагын 120 гаруй албан

хаагчид оролцож, хуваарилагдсан газруудад, маршрутын дагуу цэвэрлэгээ хийж, 2 машин хогийг нэгдсэн цэгт төвлөрүүлж устгал хийлээ.

Тэтгэврийн даатгалын сангаас нийт 402 тэтгэвэр авагчдад 144640,9 мянган төгрөгийн тэтгэвэр бүрэн олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 303, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 29 иргэн байна. Сайн дурын даатгалд нийт 69 даатгуулагчийн 3999,4 мянган төгрөг төвлөрүүлж, 2 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажиллав.

Эрүүл мэндийн даатгалд 15 даатгуулагчийн 697,2 мянган төгрөгийн орлого орууллаа. Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжит даатгуулагчдад 4075,7 мян төг, 1 даатгуулагчдад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж 68,2 төгрөгийг тус тус олголоо.

Иргэний бүртгэлээр нийт 58 иргэнд үйлчилснээс төрсний бүртгэл 10, гэрлэлт 2, нас барсны бүртгэл 2, ургийн овог, эцэг эхийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 1, иргэний үнэмлэх олголт 14, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 11-ийг тус тус гаргаж, 18 иргэнд лавлагаа магадлагаа олгож, 16 нас хүрч иргэний үнэмлэх авах 65 иргэн, 25 насны сунгалтаа хийлгэх 60 иргэн, 45 насны сунгалтаа хийлгэх 28 иргэний судалгааг гаргаж шинэчилсэн бүртгэлд хамруулж ажиллалаа.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд ургийн овог ороогүй 2, эцэг эхийн мэдээлэлд ороогүй 3 иргэн, хаяг нь ороогүй 1 иргэний материалыг тухай бүрт нь хүлээн авч, холбогдох мэргэжилтэнд уламжлан бүртгэлд хамруулав.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр 37 хүнд 10.7 сая, Ахмад настаны асаргаа 55 хүнд 4.6 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа 19 хүнд 1.6 сая, Тэжээгчээ алдсаны тэтгэмж 12 хүнд 3.6 сая, Өрх толгойлсон 0-18 насны хүүхэдтэй эцэг эхэд олгох тэтгэмж 5 хүнд 2.1 сая, Цалинтай ээж 161 эхэд 8.0 сая, Жирэмсэн эхийн тэтгэмж 42 эхэд 1.7 сая, Насны хишиг 2 ахмадад 160 мянга, Алдарт эхийн одон 4 хүнд 400 мянга, Хүүхдийн мөнгө 1265 хүүхдэд 12.7 сая, Хүнсний эрхийн бичиг 33 өрх 2.8 сая нийт 49.6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олголоо.

Хүнсний эрүүл ахуйн байдалд хяналт тавих зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн нар худалдаа үйлчилгээ эрхлэж байгаа 6 дэлгүүр, албан байгууллагын 3 гал тогоонд хяналт шалгалт хийлээ. Хяналтаар хугацаа дууссан, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүн байгаагүй, ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Сумын Эрүүл мэндийн төв нь иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, нийт дуудлага 26 удаагийн дуудлагаар ажиллаж, 27 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулатороор эмчийн үзлэгт 64 иргэн хамрагдав. Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 30, Сэргээн засах эмчилгээнд 10, Оношилгоо шинжилгээнд 28 хүн хамруулан эмчилгээ сувилгааг стандартын дагуу хийж байна

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж эхийг цаг тухайд нь хяналтанд авч, төрсөн эх нярайг 7 хоногт 1 удаа эргэлтээр үзлэг хийж байна. Зорилтот бүлгийн 30-60 насны эрт илрүүлэг шинжилгээнд 168, хеликобактерийн шинжилгээнд 6, сахарын шинжилгээнд 7, Цагаан хорхойн шижилгээнд 140 иргэнийг хамруулж оношлов.

Коронавирус өвчний талаарх мэдээллийг “Дөргөн ЭМТ” цахим хуудсаар болон гарын авлага байдлаар ард иргэдэд мэдээлэл өгч, ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийх, агаар салхи оруулах, онцын шаардлагагүй бол гадуур явахгүй байх, амны хаалтаа тогтмол хэрэглэх зэрэг зөвлөмжүүдийг өгч, хяналт тавин ажиллаж, 97146549 дугаартай эмнэлэгийн дуудлага хүлээн авах утсыг ажиллуулж, ард иргэдэд зөвлөгөө өгч байна.

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын Тамгын газрын хурал 1 удаа, Онцгой комиссын хурал 1 удаа хуралдаж, цаг үеийн ажлын талаар хэлэлцэн, холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажиллав.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ep.mongolia.mn системээр цахимаар тайлант 3 дугаар сард 20 албан бичиг хүлээн авч, 30 албан бичиг төлөвлөн холбогдох газарт уламжлав. Сумын Засаг даргын 13 захирамж гаргаж, бүртгэл хяналтанд авч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Архиваас малын “А” дансны түүвэр, лавлагаа, хүн амын бүртгэлээс 3 иргэнд лавлагаа олгож, 2019-2020 онд архивын лавлагаа авсан 25 иргэний лавлагааг дахин гаргаж Нийгмийн даатгалын байцаагчид хүлээлгэж өглөө.

Улаанбаатар хот, бусад голомттой бүсээс ирсэн иргэдийг гэрийн ажиглалтанд тусгаарлаж, багийн Засаг дарга, Цагдаагийн ажилтнуудтай хамтран хяналт тавин ажиллалааьж ажиллалаа.

Иргэний танхимд 4 удаагийн цахим уулзалт, хурал, сургалт зохион байгуулагдлаа. Иргэд, аж ахуй нэгжийн хүсэлтээр <https://operator.e-mongolia.mn/> системд 30 хүсэлт үүсгэж, 19 лавлагаа, тодорхойлолтыг гаргаж өгч үйлчлэв.

Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар байнгын асаргаа шаардлагатай 2 иргэнийг асаргааны тэтгэмжид оруулж, 1 иргэний асран хамгаалагчийг өөрчилсөн. Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авдаг 21 өрхийн 128 иргэнд 1672.000 төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг “Их Хунт” аж ахуй нэгжээр олгуулахаар шийдвэрлэв. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 21 өрхийн харъяалалыг Улсын бүртгэлийн програмтай тулгалт хийж баталгаажууллаа.

Ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа 86 иргэнийг ХЗЗ-2 маягтын дагуу бүртгэж, шинээр ажилд орсон 1 иргэний мэдээллийг Lmis.gov.mn програмд шивж ажлын байрны мэдээнд тусгуулав. Шинэ төрсөн 2 хүүхэд, жирэмсэн 4 эх, халамжийн тэтгэвэр авдаг 2 иргэний тэтгэврийн сунгалт, 1 иргэний хиймэл шүдний хөнгөлөлт, 1 иргэний эмчилгээний зардлын баримтыг хүлээн авч програмд шивж баталгаажууллаа.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэдийн хувийн хэргийн баяжилт хийж 12 иргэний цахим үнэмлэхийн хугацаа дууссаныг шинээр бүрдүүлж баримтанд хавсаргав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний зээлийн эргэн төлөлтийн хуваарь гаргаж, 100.0 мян.төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэний 200.0 мян төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг тус тус төлүүлэв.

Тайлант 2021 оны 3 дугаар сард нас барсан нэг иргэнд 1.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, 1 иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоож, нийт 308 иргэнд 115385.5 мян төгрөгийн тэтгэвэр олголоо. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 19 иргэн хамрагдаж 925.1 мян төг, эрүүл мэндийн даатгалд 23 иргэн хамрагдаж 1130.9 мян төг, нөхөн даатгалд 1 иргэнийг хамруулж 336.0 мян төгрөгийн орлого тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

Хүүхдийн эрх зөрчигдсөн болон гэр бүлийн хүчирхийлийн 2 өргөдлийг хүлээн авч кейс бүрдүүлэлтийг хийж, 1 өргөдлийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.

Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр тайлант 3 дугаар сард төрөлт 1, баг хоорондын шилжилт хөдөлгөөн 1, цахим үнэмлэх 11 иргэн, шинээр 16 нас хүрч цахим үнэмлэх захиалсан 7, шинээр цахим үнэмлэх 1, 25 насны сунгалт 4, 45 насны сунгалт 5 хийлгэж, цахим үнэмлэхээ гээгдүүлж 1 иргэн цахим үнэмлэх захиалан

олгож, Цахим үнэмлэхний лавлагаа 2, Төрсний гэрчилгээний дахин олголтын бүртгэл 1, Төрсний гэрчилгээний лавлагаа 1, Нас барсны лавлагаа 1, Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа 1 нийт 8 иргэнд дээрх төрлийн лавлагаа олгов.

Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр “Ховд Цэнхэрийн долгион” ХХК-ийн материалыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэн гэрчилгээг шинэчилж олгосон төдийгүй хамтран өмчлөлөө салгуулах 3 иргэний, Үл хөдлөх хөрөнгөө хэсэгчилж хуваах 1 иргэний, Шинээр газрын гэрчилгээ авах 2 иргэний материалыг холбогдох газарт хүргүүлж, нийт 39 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Газар эзэмших, хэмжээ талбай өөрчлүүлэх, Э дугаар авч улсын бүртгэлд бүртгүүлэх, тухай 31 өргөдөл хүлээн авч, ажиллаж байна. Монгол улсын Засгийн газраас 3 хувийн хүүтэй зээл аж ахуй нэгж, байгууллагад олгож байгаатай холбоотой, газрын хэмжээ хаяг зөрүүтэй газрын кадастрын мэдээллийн санд ороогүй, хамтран өмчлөл салгаагүй зэрэг асуудалтай газруудын баримт бичгийг хүлээн авч иргэдэд холбогдох мэдээллийг өгч байна. Нөхөн бүрдүүлэлтээр эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөх 45 өргөдөл хүлээн авч холболт хийлгэхээр Кадастрын мэргэжилтэнд хүргүүлж холбуулах ажил хийгдэж байна.

Газрын төлбөрийн нэхэмжлэлийг 525 нэгж талбарт үүсгэж, нэхэмжлэл үүсэхгүй 157 нэгж талбар байгаагаас 114 нэгж талбарыг аймгийн Татварын хэлтэст илгээж ногдуулалтыг хийж, нэхэмжлэл үүсгэв. Ногдуулалт бодогдохгүй байгаа 43 нэгж талбарт татвар төлөгчийн дугаар авахаар төлөвлөсөн.

Сумын Санхүүгийн алба нь 3 дугаар сарын хуваарьт 48 930 000 төгрөгийг ИТХ-д 4 482 600 төгрөг, ЗДТГ-т 28 603 400 төгрөг, Соёлын төвд 9 337 900 төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 3 031 400 төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 1 691 700 төгрөг, Эрүүл мэндийн төвд 173 000 төгрөг тус тус олголоо.

Төсөвт байгууллагуудын гүйлгээг шивэх, төрийн сангийн бусад үйлчилгээ үзүүлэх, статистик мэдээ гаргаж, 6 төсөвт байгууллагын төрийн сангийн данснаас 27 төлбөрийн хүсэлтээр 17595.4 мянган төгрөгийн гүйлгээ шивлээ.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан, зээлийн гэрээний хугацаа дууссан, графикт хугацаа хэтэрсэн 46 зээлдэгчийн 86.833.098 төгрөгийн зээлийн судалгааг гаргаж зээлдэгч нарт зээл барагдуулах тухай мэдэгдэх хуудсыг 12 зээлдэгчид хүргүүлэн 20

зээлдэгчтэй утсаар ярьж сум хөгжүүлэх сангийн 100161155401 тоот дансанд 5 зээлдэгчийн 1.250.000 төгрөг төвлөрүүлээ.

Оны эхний улиралын байдлаар адуу 16, үхэр 98, хонь 125, ямаа 126 хорогдож нийт 365 том мал хорогдсон, төл бойжилт сумын дүнгээр 47918 толгой эх мал төллөхөөс бод малын 10 хувь, бог малын 30 хувь буюу 13146 толгой бог, 481 бод мал төллөж гарсан төлийн 98 хувь нь эсэн мэнд бойжиж байна. Малчдын хүсэлтээр хямдарсан үнээр 800 боодол өвс, 200 уут тэжээл татан авч хямдралтай үнээр малчдад олголоо.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сумын мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, шимэгчтэх өвчний эрсдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг сум, багийн түвшинд зохион байгуулах, мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хянаж, мал эмнэлгийн нэгдсэн системийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган, малчдад мал эмнэлгийн чанартай үйлчилгээг үзүүлэх зорилгоор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга, сумын Засаг дарга, сумын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд 2021 онд хийж хэрэгжүүлэх ажлын гурвалсан гэрээ байгууллаа.

Малын халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх 400 гаруй мянган төгрөгийн эм, биобэлдмэлээр үйлчилгээ үзүүлэн, малчдад малын зарим нэр төрлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Аймгийн Мал эмнэлгийн газраас ишигний шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин татан авч Цэнхэрийн долгион МЭҮН-д 3000 тун, Мөнххайрхан царцаа МЭҮН-д 5000 тун нийт 8000 тун вакцин хуваарилан ажлыг эхлүүлээд байна.

Сумын Эрүүл мэндийн төвд нийт 26 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Эмийн бус эмчилгээгээр 24 хүнд үйлчилж, урьдчилан сэргийлэх зорилгоор 0-2 насны хүүхдийг товлолын дагуу дархлаажуулалтанд хамрууллаа. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт ирж байгаа иргэд, оюутнуудыг шинжилгээнд хамруулж, гэрийн ажиглалтын зөвлөмж хүргүүлээд байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР